

БАГАНУУР ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Багануур дүүргийн Шүүхийн Тамгын газар нь ШЕЗ-өөс 2015 онд дэвшүүлсэн бодлого, зорилтын хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан батлуулж, хууль тогтоомж эрх зүйн актын хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Тамгын газрын тайланг ШЕЗ-ийн 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 95 дугаар тогтоолоор баталсан журмын стандартад нийцүүлж гаргалаа.

Шүүгчийн хараат бус, бие даасан байдлыг хангаж, хамгаалах, шүүхийн захиргааны удирдлагыг оновчтой хэрэгжүүлэн, хүний нөөц, төсөв санхүү, дэд бүтцийн удирдлагыг тасралтгүй хэрэгжүүлж, шүүхийн нээлттэй ил тод байдлыг хангаснаар шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Нэг. ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАЖ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

Шүүгчийн хараат бус, бие даасан байдлыг ханган, хамгаалж ажилласнаар тухайн шүүхүүд тайлангийн хугацаанд үйл ажиллагаагаа хэвийн явууллаа.

Шүүгчид нөлөөлөх, нөлөөлгийн мэдүүлэг хөтлөх нөхцөлтэй холбогдуулан гаргасан ШЕЗ-ийн тогтоолын тодорхой хэсгээс дүүргийн нутгийн захиргааны удирдах ажилтнууд, Цагдаагийн хэлтсийн албан хаагчид, иргэдэд сургалт зохион байгуулж орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллав. Сургалтанд 500 гаруй иргэн хамрагдсан байна.

Шүүгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг 10 дугаар тойргийн Тахарын албаны Багануур дахь хэсэгтэй хамтран зохион байгуулж байгаа ба Тахарын Багануур дахь хэсэг нь нийт 13 алба хаагч, УАЗ-469 маркийн тээврийн хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэж байна.

Оны эхний хагас жилд тус шүүхээр үйлчлүүлсэн 9737 иргэний бичиг баримтанд үзлэг шалгалт хийж хяналт тавьж ажилласан ба 2163 оролцогчтой эрүүгийн 535, иргэний 357, нийт 892 шүүх хуралд дэг журам сахиулж, шүүх хуралдаанд оролцож буй шүүгчдэгч нарын биед үзлэг шалгалт хийж хяналт тавьж ажилласан байна. Тайлангийн хугацаанд шүүгчдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад аюулгүй байдлаа хангуулахаар 5 удаа хүсэлт ирүүлснийг Тахарын албанд уламжлан холбогдох хамгаалалтыг зохион байгуулж, аюулгүй байдлыг хангууллаа. Шүүхүүдийн байрыг бүрэн камержуулаад байна.

Хорих ангиуд дахь хянан магадлангийн 28 хуралд шүүгчийн аюулгүй байдлыг хангаж ажиллав.

Шүүхийн хэвийн ажиллах эдийн засаг, хүний нөөц, техник зохион байгуулалтын нөхцөл бололцоог тухай бүрт ханган ажиллалаа. Оны эхний хагас жилд шүүгчдийн цалин, томилолтонд **274.112,7** сая, хоол, унааны зардалд **6.392,0** сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Батлагдсан орон тооны дагуу шүүгчийн туслах 8, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга 3, бичиг хүргэгч 2 ажилтан тус тусын шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлж ажиллажээ. Шүүхээс бичиг хүргэгчээр 3580 бичиг хэргийн оролцогчдод хүргэгдсэн байна.

Шүүгч тус бүр өөрийн албан өрөөнд тус тусдаа ажил үүрэг гүйцэтгэж байгаа ба гарын дор зайлшгүй шаардагдах тавилга хэрэгсэл, техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна. Шүүгчдийн нэр дээр нийт 54.319,6 сая төгрөгийн тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж картлагдан ашиглагдаж байгаагийн зэрэгцээ оны эцэст шүүн таслах ажиллагааны албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн зардалд 5.558,1 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хоёр.ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Тус газар нь өдөр тутмын үйл ажиллагаандаа Шүүхийн тухай багц хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллалаа. Шүүхийн хүний нөөц, хэргийн хөдөлгөөн, сургалт, сурталчилгаа, төсөв санхүү, харилцаа холбоо, техник хангамж, холбогдох бусад асуудлыг тухай бүрт мэргэжлийн удирдлагаар хангаж үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хэвийн хадгаллаа.2015 оны 01-р сард төрийн захиргааны 15, төрийн үйлчилгээний 11 албан хаагчтай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулж гэрээний биелэлтэнд сар бүр явцын хяналт хийж хагас жилээр дүгнэж үнэлэлт дүгнэлт өгсөн. ШЕЗ-өөс томилогдсон ажлын хэсэг хуулийн хэрэгжилтийн талаар 2 удаа шалган, зааварчилга өгсний зэрэгцээ Дотоод аудитын албаны санхүүгийн шалгалтанд 2013-2015 оны санхүүгийн баримтаа бүрэн хамрууллаа. 2015 оны 03 дугаар сард хийгдсэн ШЕЗ-ийн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж төлөвлөгөөний биелэлтийг 10 дугаар сарын 01-ний өдрөөр гарган хүргүүлсэн.

Тамгын газраас гарч буй эрх зүйн актын хууль зүйн үндэслэлд онцлон анхаарч ажилласны дээр шүүгч, ажиллагсдын нийгмийн болон бусад харилцааг хууль зүйн дагуу зохицуулахад түлхүү анхаарлаа.

Эвлэрүүлэн зуучлалын талаар

Тус Тамгын газарт орон тооны 1, орон тооны бус 1 эвлэрүүлэн зуучлагч ажиллаж байна. Эвлэрүүлэн зуучлагч нь 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар 351 өргөдөл хүлээж авснаас 301 өргөдөл шийдвэрлээд байна. Эдгээрийн 246-д эвлэрлийн гэрээ байгуулж, 2 өргөдөл амжилтгүй болсон, 23-ыг буцааж 30-ыг хүлээн авахаас татгалзсан.Тайлангийн хугацаанд Эвлэрүүлэн зуучлагчид 540 иргэн хандсан байна. Маргааны төрлөөр авч үзвэл иргэний эрх зүйн маргаан 346, гэр бүлийн харилцаанаас үүсэн маргаан 4, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан 1 байна. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг анх удаа онлайнаар амжилттай зохион байгууллаа. 10-р сараас Эвлэрүүлэн зуучлалын програм шинээр ашиглаж эхлээд байна.Эвлэрүүлэн зуучлалын талаар 10 удаагийн сургалт зохион байгуулж 250 гаруй гарын авлага материал тараагдсан байна.Ерөнхий болосролын сургуулийн 11-12-р ангийн сурагчдын дунд Эвлэрүүлэн зуучлалын талаар сургалт зохион байгуулж эссэ бичлэгийн уралдаан зарлаж дүгнэлээ.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн талаар

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон хороодоос шүүхэд иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон ажиллах 65 иргэдийн нэрсийн жагсаалтыг гаргуулан авч ШЕЗ-өөр батлуулсан.

ДЭХАШ-ны 3 дугаар шүүхэд 44 иргэн батлагдсанаас хуралдаанд оролцсон 10, нөөцөд сонгогдсон 14, хүлээгдэж буй 20 төлөөлөгч, ДИХАШ-ны 3 дугаар шүүхэд 21 иргэн төлөөлөгчөөр оролцохоор батлагдсанаас хуралдаанд оролцсон 10, нөөцөд сонгогдсон 8, хүлээгдэж буй 3 төлөөлөгч сонгогдон оролцоод байна. Хэргийн ачааллаас хамаарч нэмэлтээр 24 иргэдийн төлөөлөгчийг батлуулахаар ШЕЗ-д нэрсийг хүргүүлээд байна.

Иргэдийн төлөөлөгчийн бүртгэлийн дэвтэр нээж шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгчийн ирцийг бүртгэж, шүүх хуралдааны товыг сонгосон өдөртөө мэдэгдэх хуудсаар мэдэгдэж мөн иргэдийн төлөөлөгчөөр нөлөөллийн мэдүүлэг танилцуулсан баримт, хэргийн материал танилцуулж, танилцуулсан талаар баримт үйлдэж шүүх хуралдаан эхлэхээс өмнө тангарагийг өргүүлэн бүртгэлд тэмдэглэж баталгаажуулж байна. Эрүүгийн шүүхийн Ерөнхий шүүгч болон Тамгын газрын дарга нар ШЕЗ-өөс КМЈЗ телевизтэй хамтран зохион байгуулсан Иргэдийн төлөөлөгчдийн талаарх нэвтрүүлэгт оролцож хуулийн хэрэгжилтийн талаар ярилцлага өглөө.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль, шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, ажиллуулах журамын хүрээнд дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон хороодоос шүүхэд иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон ажиллах 114 иргэдийн нэрсийн жагсаалтыг гаргуулан авч ШЕЗ-өөр батлуулсан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2015 оны 42 дугаартай тогтоолоор шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг шинэчлэн 88 болгож баталсан. 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Багануур дүүргийн Иргэн, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Иргэдийн төлөөлөгчийн програмыг нэгтгэн нэг болгож долоо хоног бүр Тамгын газрын даргын тушаалаар иргэдийн төлөөлөгчийн нэрсийн дэд жагсаалтыг батлуулж байна.

Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 17 шүүх хуралдаанд 17 иргэдийн төлөөлөгч, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 7 шүүх хуралдаанд 8 иргэдийн төлөөлөгч оролцсон байна. Шүүхийн иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдааны товыг ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэж, хэргийн материал, эрх үүргийн танилцуулсан талаар баримт үйлдэж, шүүх хуралдаан болохоос 30 минутын өмнө шүүх хуралдааны нийтлэг журам, дэгийн талаар шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн мэдээлэл өгч, шүүх хуралдааны өмнө тангараг өргүүлж ажиллаж байна. Иргэн, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 2016 онд иргэдийн төлөөлөгч сонгох бэлтгэл ажлын хүрээнд дүүргийн 25-аас дээш насны 14484 иргэний нэрсийн жагсаалтыг гаргаж Шүүхийн Ерөнхий зөвлөлд хүргүүлсэн.

Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Багануур дүүргийн шүүхийн Тамгын газраас “Шүүх дэх иргэдийн оролцоо” сэдэвт уулзалт ярилцлагыг 2015 оны 11 сарын 11-ний өдөр дүүргийн Засаг Даргын Тамгын Газрын 219 тоот танхимд зохион байгууллаа. Уулзалтанд дүүргийн байгууллага аж ахуйн нэгжийн удирдлагууд, төрийн албан

хаагчид, хорооны ажлын албаныхан, хэсгийн ахлагчид, шүүхэд иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэд болон дүүргийн иргэдийн төлөөлөл болсон 170 гаруй хүмүүс оролцлоо.

Хавтасг хэрэг илгээх, хүлээн авах талаар

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2014 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 10 дугаартай тогтоолоор баталсан хавтас хэрэг илгээх журмын дагуу богцоор эрүүгийн 41 хэрэг илгээснээс 7 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж, 30-ыг буцаан авч, иргэний 36 хэрэг илгээж, 2 хэргийг харъяалалын дагуу шилжүүлж, 21-ийг буцаан авсан байна. Хэргийн хөдөлгөөн, богцын тооноос хамаарч зарим тохиолдолд богцгүй болох асуудал ганц нэг удаа гарсныг эс тооцвол уг ажиллагаанд ямар нэгэн хүндрэл бэрхшээл гаралгүй хэвийн явагдаж байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар

ИХАШ-ны шүүхэд хөтлөгдвөл зохих 22 төрлийн бүртгэл, ЭХАШ-ны шүүхийн үндсэн 14, туслах 26, нийт 40 төрлийн бүртгэл, Тамгын газарт 6 төрлийн бүртгэл зааврын дагуу хөтлөгдөн хянагдаж холбогдох мэдээлэл судалгаа бүртгэлийн дагуу нэгтгэгдэж байна.

Тамгын газрын даргын тушаал 100 гарснаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой 81, хүний нөөцтэй холбоотой 19 тушаал байна. Тамгын газарт 397 албан бичиг ирж, 278 албан бичиг гадагш явсан ба хугацаатай албан бичгийн хариуг хуульд заасан хугацаанд хүргүүлж ажиллалаа.

Тус шүүхийн архивт тооллогоор 2002 оноос хойших байнга хадгалагдах иргэний хэрэг 232 нэгж, түр хадгалах иргэний хэрэг 8526 нэгж, шүүхийн байнга хадгалах эрхийн акт 55731 нэгж, түр хадгалах эрхийн акт 960 нэгж, Тамгын газрын байнга хадгалах 75 нэгж, түр хадгалагдах 136 нэгж, эрүүгийн 39 хэрэг, захиргааны зөрчлийн материал 184 нэгж, хянан магадлангийн 72 нэгж нийт 65955 нэгж материал хадгалагдаж байна.

Иргэн байгууллага, аж ахуйн нэгжийн хүсэлтээр 196 удаа архивын лавлагаа гаргаж өгч архивын тооллогыг 2015 оны 01-дүгээр сард явуулж дүн мэдээг хүргүүлсэн.

Архивт нийт 10 төрлийн бүртгэл зааврын дагуу хөтлөгдөж байгаа ба архивт хадгалагдаж байгаа 1980-2013 оны хадгаламжийн нэгжийг цахимжуулах ажлыг хийж дуусгасан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албанаас ирүүлсэн 2015 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 04/26 тоот албан бичгийн дагуу 2015 оны 01 сарын 10-наас 16-ны өдрүүдэд Тамгын газрын Архивын нэгдсэн тооллого явуулж, дүнг нэгтгэн Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүллээ. Тооллогыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Шүүхийн архивын ажиллах журам батлах тухай” 29 дүгээр тогтоолын хүрээнд явууллаа.

Тооллогод шүүхийн архивт түр болон байнга хадгалагдаж байгаа 1980-2014 оны эрүү, иргэн, захиргааны зөрчлийн материал болон санхүүгийн баримтууд хамрагдлаа. Тус архивт 1980-2014 оны байнга болон түр хадгалагдах 15268 хадгаламжийн нэгж тоологдсон байна.

2014 оны Эрүүгийн 129 хавтаст хэргийг УЕП-ын дэргэдэх ЭХ-ийн төв архивт 2015 оны 03 сарын 16-17ны өдрүүдэд тушаалаа. Үүнээс: Байнга хадгалах эрүүгийн хэрэг 17 хавтас, түр хадгалах эрүүгийн хэрэг 112 хавтас, шийтгэх тогтоолын өнгөн хувь 2 хавтас, 2014 оны эрүүгийн үндсэн бүртгэл 29 хавтас тус тус тушаагдав.

2014 оны хянан магадлангийн материал 220 хавтсыг НПГ-ын дэргэдэх Эрүүгийн хэргийн салбар архивт 2015 оны 03 сарын 16-нд тушаасан бөгөөд хянан магадлангийн захирамжийн эх хувь 2 хавтсыг тушаасан байна.

Эд мөрийн баримтыг хадгалах, хамгаалах чиглэлээр

Эрүүгийн 134 хэрэгт хураагдсан 191 эд мөрийн баримтыг хүлээн авч 33 хэргийн 101 эд мөрийн баримтыг устгаж, 4 хэргийн 58 эд мөрийн баримтыг шилжүүлж, 2 хэргийн 2 эд мөрийн баримтыг хэрэгт хавсаргаж, 5 хэргийн 13 эд мөрийн баримтыг буцаан олгож, 1 хэргийн 1 эд мөрийн баримтыг улсын орлого болгож, үлдэгдэл 3 хэргийн 16 эд мөрийн баримтыг зохих журмын дагуу хадгалж байна.

Хэргийн хөдөлгөөний чиглэлээр

Эрүү, иргэний хэргийн хөдөлгөөний стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөж, хэвшүүлэх ажлыг зохион байгуулж, ажлын сахилга хариуцлагыг өндөржүүлэн шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын ажлыг сар бүр шалгаж ажиллалаа. Шүүгчийн туслах болон шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын ажлын хариуцлагыг сайжруулж, шүүх, түүний тамгын газраас иргэд, болоод хэргийн оролцогчдод хүргэж буй үйл ажиллагааг стандарт шаардлагын түвшинд хүргэх, шүүн таслах ажиллагааг хэвийн явуулахад анхаарч ажиллаж байна. Шүүхээс бичиг хүргэгчээр 3580 бичиг хэргийн оролцогчдод хүргэгдсэн байна.

Иргэний хэргийн шүүн таслах ажлын талаар

Тайлангийн хугацаанд 2014 оны үлдэгдэл 88, шинээр 863, нийт 951 нэхэмжлэл хүлээн аваад байгаагаас 131 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, 8 нэхэмжлэлийг нэхэмжлэгч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй үндэслэлээр буцаан, 685 хэрэг хянан шийдвэрлэн, 56 хэргийг түдгэлзүүлэн, 5 хэргийг шилжүүлж, 76 хэргийн үлдэгдэлтэй байна. Эвлэрүүлэн зуучлагчаас ирүүлсэн 255 материалыг баталгаажуулсан байна.

Шүүхийн тогтоол 17, шийдвэр 685, шүүгчийн захирамж 2366, шийтгэвэр 14 тус тус гарч бүртгэлийн програмд гүйцэтгэх хуудас 654, давж заалдах болон хяналтын 33 гомдол, албадан гүйцэтгэх 342 хүсэлт бүртгэгдсэн байна.

Иргэний 68 хэргийн шүүх хуралдаан холбогдох шалтгааны улмаас хойшлогдсон нь нийт товлогдсон шүүх хуралдааны 19.3 хувийг эзэлж байна.

Эрүүгийн хэргийн шүүн таслах ажлын талаар

Тайлангийн хугацаанд Эрүүгийн 174 яллагдагчид холбогдох 134 хэрэг хүлээн авч 2 яллагдагчид холбогдох 2 хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцааж, 12 яллагдагчид холбогдох 7 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 152 шүүгдэгчид

холбогдох 119 хэргийг хянан шийдвэрлэж 8 шүүгдэгчид холбогдох 6 хэргийн үлдэгдэлтэй байна.

Давж заалдах болон хяналтын шатаар тус шүүхийн 26 хэрэг хянагдсанаас 10 буюу 38.4 хувь нь хэвээр, 12 хэрэг буюу 46.1 хувь нь хүчингүй болж үлдэгдэл хэрэг 4 байна. 64 хүнд холбогдох 39 эрүүгийн хэргийн шүүх хуралдаан хойшилсон нь нийт товлогдсон шүүх хуралдааны 24.6 хувийг эзэлж байна.

Захиргааны зөрчлийн 254 материал хүлээн авснаас 5 материалыг нотлох баримтын шаардлага хангаагүй гэдгээр арга хэмжээ авахаас татгалзаж буцааж, 249 хүнд холбогдох 249 зөрчлийг хянан шийдвэрлэснээс 56 хүнийг торгож, 193 хүнийг баривчилсан байна.

Сэжигтнийг хойшлуулшгүй ажиллагаагаар баривчлуулах тогтоол шүүхэд 23 ирснээс 19 сэжигтнийг баривчилж, 4 сэжигтнийг сулласан байна. Сэжигтнийг цагдан хорих 33, яллагдагчаар үргэлжлүүлэн цагдан хорих 29, нийт 62 санал хүлээн авч шийдвэрлэжээ. Цагдан хорих арга хэмжээг өөрчилсөн 19, цагдан хорих хугацааг сунгасан 21, өөр газар шилжүүлэн хорьсон 4, сэжигтэн, яллагдагчийг цагдан хорихоос татгалзсан 2 захирамж тус тус гарсан байна.

Нийт 44 сэжигтэн, яллагдагчид холбогдох 131 захирамж гараад байна.

ШШГЕГ-ын харьяа хорих ангиудаас 400 санал хүлээн авч 68 ялтныг тэнсэн суллах, 52 ялтныг дэглэм бууруулах, 1 ялтныг дэглэмийг дээшлүүлж, 10 ялтныг харъяалалын дагуу шилжүүлж, 94 ялтныг өршөөн хэлтрүүлж, 175 ялтны ялаас өршөөн хассан шийдвэр гаргажээ. 14 өргөдөл гомдол хүлээн авч хуулийн хугацаанд үлдэгдэлгүй шийдвэрлэсэн байна.

Програм хангамж, мэдээллийн технологийн талаар:

Байгууллагын албан хэрэгцээнд 34 компьютер, 1 хувилагч, 8 хэвлэгч, 19 хяналтын камер болон бусад тоног төхөөрөмж, дотоод болон интернэтийн сүлжээний хэвийн, тасралтгүй ажиллагааны бүрэн бүтэн байдлыг хангаж техник хангамжийн бүртгэлийг хөтлөн ажиллаж байна.

Шүүхийн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан онлайн хурлуудыг явуулах бэлтгэл ажлыг хангаснаар 2015 онд эрүүгийн 1 хурал, эвлэрүүлэн зуучлалын 1 ажиллагаа, ШЕЗөвлөлөөс зохион байгуулсан нийт 5 сургалт, 3 хэлэлцүүлэгт онлайн ашиглалаа.

Програм хангамж, тоног төхөөрөмжийн 42 гэмтэл, 36 сүлжээний доголдлыг бүрэн арилгаж ажилласан. Үүнээс үзвэл сард дунджаар 2-3 гэмтэл, сүлжээний доголдол гарч байна.

baganuurshuukh.mn сайтын загварын шинэчлэлийг хийж, цаг үеийн ажлын мэдээ мэдээллийг тухай бүрт www.baganuurshuukh.mn сайтад байршуулж төрийн үйл ажиллагааг иргэдэд сурталчиллаа. Сайтад нийт 71 мэдээ мэдээлэл байршуулсан байна.

Нэхэмжлэлийн загвар, хохирогчийн эрх үүрэг, нэхэмжлэгчийн эрх үүрэг гэх мэт мэдээллүүдийг иргэд татаж авахад зориулан shuukh-help.pro –ийг хийж ашиглаж байна.

Шүүхийн мэдээлэл технологийн үйл ажиллагааг гадны нөлөөнөөс хамгаалах зорилгоор WI-FI router ашиглахаас татгалзасны дээр IP address search суулган сүлжээнд гаднаас ямар нэгэн компьютер нэвтэрч буй эсэхийг шалгаж, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Мэдээллийг тодорхой хугацаанд файлаар архивлах зорилгоор server компьютерт байгаа нийт файлыг хард дискэнд буулган цахим архив үүсгэн ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд 577 шүүх хуралдааны явцын дүрс бичлэгийг хард дискэнд хуулж, зохих журмын дагуу архивлав.

Тайлан мэдээний талаар:

Эрүүгийн шүүхээс 23 төрлийн, Иргэний шүүхээс 12 төрлийн, Тамгын газраас 44 төрлийн тайлан мэдээ, судалгааг хуулийн хугацаанд гаргаж холбогдох газарт, үйл ажиллагааны явцад ШЕЗ болон холбогдох бусад газруудаас ирүүлсэн 13 төрлийн асуулга, судалгааг тогтоосон хугацаанд гаргаж хүргүүлсэн байна. ШЕЗ-өөс ирүүлсэн 47 албан бичгээс хугацаатай 19 албан бичгийн хариуг тогтоосон хугацаанд хүргүүлсэн ба 10 төрлийн судалгаа гарган нэгтгэж хүргүүлсэн байна. Улсын дээд Шүүхэд 5, Нийслэлийн давж заалдах шатны шүүхүүдэд 4, ТЕГ-т 6, бусад газарт 5 судалгааг тус тус гаргаж хүргүүллээ.

ГУРАВ.ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР:

Төлөвлөлт, судалгаа, өөрчлөлтийн талаар

Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 5, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 4, нийт 9 шүүгч, Тамгын газарт төрийн захиргааны 15, үйлчилгээний 11, нийт 34 ажилтан, албан хаагчийн орон тоо батлагдсанаас тайлангийн хугацаанд батлагдсан орон тоогоор бүрэн ажиллалаа.

1-дүгээр улиралд төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг гаргаж ТАЗ-д хүргүүлсэн ба 2015 оны 5-р сард ШЕЗ-ийн хүний нөөцийн шинэчилсэн програмд бүрэлдэхүүний мэдээллийн санг шинээр тусгав. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны хүний нөөцийн програм шинэчлэгдсэнтэй холбогдон шүүгч ажилтнуудын анкетыг дахин авч программын баяжилтыг шинэчлэн хийж байна.

Байгууллагад хүний нөөцтэй холбоотой 4 төрлийн нэгдсэн судалгаа хөтлөгдөж байна.

Тайлангийн хугацаанд төрийн үйлчилгээний 1 албан хаагч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, төрийн захиргааны 1 албан хаагч шилжин томилогдож, 5 албан хаагч хүүхэд төрүүлэх, асрах чөлөөтэй байна. Чөлөөлөгдсөн болон шилжсэн албан хаагчдын оронд нөөцөд байгаа шаардлага хангасан иргэдээс сонгон шалгаруулалт явуулж түр томиллоо.

Төрийн албан хаагчдын баримт бичгийн бүрдлийн талаар

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын хувийн хэргийн /эрүүл мэнд, нийгмийн даатгалын дэвтрийн бичилт/ бүрдлийг хангуулж баяжилтыг цаг тухайд хийж ажиллав. Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан

ажилтнуудтай 2015 оны үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэлд сар, улирлаар хяналт тавьж хагас жилээр үнэлэлт дүгнэлт өглөө.

Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан, их хэмжээний өөрчлөлт орсон даруйд өөрчлөлт хийлгэж ШЕЗ-д хүргүүллээ. УИХ-ын ТББХ-ны тогтоолын дагуу 2014 оны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах эрх бүхий 13 албан тушаалтны ХОМ-ийг гаргуулан авлаа. Шинээр томилогдсон албан тушаалтнуудаар нийтийн албаны ашиг сонирхлын мэдүүлэг гаргуулан АТГ-т хүргүүлж дүгнэлт гаргууллаа.

Мэргэшил, ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр

ШЕЗ-өөс болон УДШ, сургалт судалгааны бусад байгууллагаас зохион байгуулсан 29 удаагийн сургалтанд /давхардсан тоогоор/ шүүгч, шүүхийн захиргааны 14 ажилтан хамрагдсан байна. Байгууллагын дотоод сургалтыг 2015-2016-оны төлөвлөгөөний дагуу 05-дугаар сар хүртэлх хугацаанд 12 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 300 орчим суралцагч хамрагдлаа. Сургалтыг шинээр батлагдан гарч хэрэгжиж буй хууль тогтоомж, эрх зүйн актууд, уйгаржин монгол бичиг, эрүүл мэнд, зөв хооллолт, хувь хүнийг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулав. Багануур дүүрэг нь нийслэлийн 9 дүүргээс аюулын түвшний үнэлгээгээр хамгийн эрсдэлтэйд тооцогддог учраас Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үүднээс дүүргийн Онцгой байдлын хэлтэст сургалтын захиалга өгч Гамшгийн тухай ойлголт, Газар хөдлөлт, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх тухай хуулиар шүүгч ажилтнуудад сургалт зохион байгууллаа. Мөн дүүргийн Улаан загалмайн хорооноос “Анхны тусламж үзүүлэх”, “Цус алдалт”, “Ясны хугарал”, Түлэгдэлт, Хөлдөлт зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулагдлаа.

Сургалтанд хамрагдагсдаас шалгалт авч зарим нэр төрлийн хичээлүүд дээр сертификат гардууллаа. Ажилтнуудын мэргэжил, мэргэшил, дадал, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн захиргааны болон үйлчилгээний 6 ажилтныг сэлгүүлэн ажиллууллаа.

Шүүхийн Тамгын газраас шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын ажлын уялдаа холбоог сайжруулах, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Ажил мэргэжлийн уралдаан”-ыг зохион байгууллаа.

Уралдааныг хууль, эрх зүйн мэдлэгийн тест, компьютерийн түргэн бичилт, эрх зүйн бодлого, эссе бичлэг, асуулт хариултын хөгжөөнт центавр гэсэн 5 төрлөөр зохион байгуулж дүгнэлээ. Уралдаанд 3 багийн 12 ажилтан оролцсоноос Шүүгчийн туслах Т.Гантуяа ахлагчтай “Дөрвөн бэрх” баг бусдыгаа хошуучлан тэргүүн байр эзэлж, Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.

2015-2016 оны хичээлийн жилийн биеийн тамирын арга хэмжээний төлөвлөгөө хөтөлбөрүүд батлагдан 95 дугаар сургуультай байгуулсан спорт зал ашиглах гэрээний дагуу 7 хоног бүрийн Пүрэв гарагт спорт заланд тоглож байна.

Шүүгч ажилтны монгол хэл бичгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор зөв бичгийн дүрмийн үргэлжилсэн сургалт авахаар сургагч багштай тохиролцон хичээл эхлэхэд бэлэн болоод байна.

Шүүгч, ажилтны нийгмийн баталгааг хангах талаар

Батлагдсан төсөв төсвийн хуваарийн хүрээнд шүүгч, ажилтны эрүүл мэнд, нийгмийн даатгалд 65.379,5 сая, унаа хоолны зардалд 34,606,0 сая төгрөг зарцууллаа. Ажилтан албан хаагчийн ар гэрт гарсан гачигдлыг харгалзан журмын дагуу 2.800,0 сая төгрөгийн тэтгэмж, баяр тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан 1.727,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Мөн сар шинийн баяр, ахмадын баяраар өндөр настнуудад хүндэтгэл үзүүлж 300,0 төгрөг олгосон байна. Гэр хороололд амьдардаг 11 ажилтанд 1.177,0 төгрөгний тусламж үзүүлсэн. Албан хаагчдын 84 хувь нь өөрийн орон байр, гэрт, бусад нь түрээсийн орон байранд амьдарч байна. Эдгээр нь шүүхийн захиргааны ажилтнууд байна. Шүүгч, шүүхийн захиргаа, үйлчилгээний ажилтнуудыг ажиллах нөхцөл бололцоогоор хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Шүүгч Б.Нарантуяа, зохион байгуулагч Х.Бадамжаргал нар Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдлаа.

- Шүүгчийн туслах П.Нансалмаа МЗХ-ны залуу хуульч цол тэмдгээр, Иргэний хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч П.Цэцэгдулам ШЕЗ-ийн, Эрүүгийн хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч Д.Оюунбат Багануур дүүргийн хүндэт тэмдгээр шагнагдлаа.

- Багануур дүүргийн шүүх үүсч байгуулагдсаны 35 жилийн ойн хүрээнд эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан нэр бүхий 4 ажилтныг Тамгын газрын даргын шагналаар, 8 ажилтныг бусад байгууллагын шагналаар шагнууллаа.

- 2015 оны эхний хагас жилийн ажлаараа бусдыгаа хошуучилсан нэр бүхий 6 албан хаагчийг, Азийн аваргаас хүрэл медаль хүртсэн 1 сурагчийг тус бүр 50000 төгрөгөөр, шагнасан байна. Тайлангийн хугацаанд нийт 24 шүүгч, ажилтан шагнагдсан байна.

- Шүүхийн нийт ажилчин албан хаагчдыг Клиникийн 1-р төв эмнэлэгт эмнэлэгийн үзлэгт хамрууллаа.

- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын ажиллагсдын 47 хүүхдэд гарын бэлэг гардууллаа. Арга хэмжээний үеэр хүүхдийн болон залуучуудын зөвлөлийн гишүүд хүүхэд багачууддаа зориулан урлагийн тоглолт үзүүлж сонирхууллаа.

- Шүүхийн ажилтны холбоо шинээр байгуулагдсантай холбогдон Тамгын газрын захиргааны ажилтнуудын гишүүнчлэлийг шинэчилж салбар зөвлөлийн менежерээр шүүгчийн туслах Т.Түмэнжаргал томилогдлоо.

- Байгууллагын харьяалалтай 3 өндөр настанд цагаан сар, ахмадын баярыг тохиолдуулан нийт 300.0 мянган төгрөгийн мөнгөн тусламж үзүүллээ.

- Байгууллагын ажилтан албан хаагчдын ар гэрт тохиолдсон гачигдалд 1.8 сая төгрөгийн тусламж үзүүлсэн байна.

- Гэр хороололд амьдардаг 11 албан хаагчид тус бүр 3 тонн нүүрсний хөнгөлөлтийг мөнгөөр тооцож олголоо.

- Дүүргийн Засаг дарга болон газрын албаны даргын нэр дээр байгууллагын ажилтны зуслангийн байшин барихад зориулан газар олгох өгөхийг хүссэн хүсэлтийг хүргүүлээд байна.

Шүүхийн захиргааны ажилтны харилцаа, ёс зүйн талаар

ШЕЗ өөс баталсан “Шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн хорооны ажиллах журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон төрийн захиргааны албан хаагчийн болон Шүүхийн ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, хяналт тавьж мөрдүүлэх чиг үүргийн хүрээнд Тамгын газрын дотоод журамд 2 заалтаар нэмэлт өөрчлөлт оруулав.

Шүүхийн захиргааны ажилтны харилцаа, ёс зүйн талаар 2 удаагийн сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж нийт шүүхийн захиргааны ажилтнуудаас ёс зүйн асуулгаар шалгалт авч баталгаажуулсан. Шалгалтанд хамрагдагсдын дундаж үнэлгээ 80 хувьтай дүгнэгдлээ.

Байгууллагын Ёс зүйн хорооны гишүүдийн орон гарсантай холбогдон тус хороог шинэчлэн зохион байгуулж, хамт олны саналаар Ёс зүйн хорооны даргаар П.Нансалмаа, гишүүдэд Б.Жамбал, Б.Хэрлэнчимэг нар томилогдон ажиллаж байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрсөн, өгсөн үүрэг даалгавар биелүүлээгүй шүүхийн захиргааны 4 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Дөрөв: ШҮҮХИЙН ТӨСӨВ САНХҮҮ ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Шүүхийн төсөв санхүү, дэд бүтцийн талаар

2016 оны төсвийн төлөвлөлтийг 2014 оны гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөж 2015 оны 06 дугаар сард ШЕЗ-д хүргүүлсэн. 2015 онд батлагдсан төсвийг хууль, тогтоомж, төсвийн хуваарийн дагуу захиран зарцуулж, улирлын тайлан баланс, холбогдох судалгааг хугацаанд нь гаргаж Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн.

- 2015 оны тодотгосон төсвөөр тус шүүхэд 810.051.500₮ батлагдсан болно. Үүнээс 2015 оны эхний 11 сард 686.538,9 батлагдсанаас 621.030,9 төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс:
 - Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын зардалд 571.803,0 батлагдаж 474.354,6 -ны гүйцэтгэлтэй,
 - Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 65.379,5 батлагдаж 65.379,5-ны гүйцэтгэлтэй,
 - Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 16.312,2 санхүүжилт авч 16.312,2 төгрөгний гүйцэтгэлтэй ,
 - Хангамж бараа материалын зардалд 19.593,5 санхүүжилт авч 19.593,5 төгрөгний гүйцэтгэлтэй
 - Нормативт зардалд 290,0 санхүүжилт авч 290,0 төгрөгний гүйцэтгэлтэй
 - Эд хогшил урсгал засварын зардалд 2.253,0₮ санхүүжилт авч 2.253,0 төгрөгний гүйцэтгэлтэй
 - Томилолт зочны зардалд 1.121,5 ₮ санхүүжилт авч 1.121,5 төгрөгний гүйцэтгэлтэй
 - Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 2.217,7₮ санхүүжилт авч 2.217,7 төгрөгний гүйцэтгэлтэй
 - Урсгал үйл ажллагаанаас 193.000 төгрөгний орлого орсон байна.

- Бараа үйлчилгээний бусад зардалд 800,0 төгрөгний санхүүжилт авч 800,0 төгрөгний гүйцэтгэлтэй нийт 65.507,9 мянган төгрөгийн хэмнэлттэй байна.

Байгууллагын орон тооны бус эд хөрөнгийн комиссыг байгуулж хадгалалт, ашиглалт, хамгаалалтыг хариуцуулан ажиллаж байна. Үндсэн хөрөнгийн хагас жилийн тооллогыг хугацаанд нь хийж балансад тусгавал зохих хөрөнгийг бүртгэлжүүлээ. Дансаар 111.800 мянган төгрөгийн үнэ бүхий 3 нэр төрлийн авто тээврийн хэрэгсэл, 158.764,1 мянган төгрөгийн үнэ бүхий 20 нэр төрлийн тоног төхөөрөмж, 11 нэр төрлийн 105.292,7 мянган төгрөгийн үнэ бүхий тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

Шүүхийн байрны түрээсийн, ашиглалтын болон холбоо, дулаан, цахилгаан, цэвэр бохир ус, автогражын халаалтын гэрээг холбогдох газруудтай байгуулж хугацаанд нь дүгнэж, төлбөр тооцоог хийж өглөг, авлагагүй ажиллав.

ШЕЗ-ийн Дотоод аудитаас 2015 оны 03 дугаар сард Тамгын газрын 2013-2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж дараах 8 төрлийн зөвлөмжийг өгсөн байна. Зөвлөмжинд техникийн комиссын шийдвэрээр сэлбэг хэрэгсэл худалдан авах, бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа 2013 оны 68 дугаар тогтоолыг баримтлах, цалин хөлсний асуудлыг дотоод журмаар зохицуулах, гэрээ дүгнэж урамшуулал олгохдоо ТАЗ-ийн 1665 оны 96 дугаар тогтоолыг баримтлах, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, шатахууны зарцуулалтыг үнэт цаасаар тооцох зэрэг зөвлөмжийг өгчээ. Шалгалтаар санхүүгийн акт тавигдаагүй болно. ШЕЗ-өөс 2015 онд 15.887,0 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, 9.107,4 мянган төгрөгийн үнэ бүхий тавилга эд хогшил нийлүүлснийг балансад бүртгэж авсан байна.

Төсвийн хязгаарлалттай байдлаас болж санхүүгийн тайлангийн хугацаанд цалин, НДШ, ХХОАТ, тэтгэмж урамшууллаас бусад сангийн зардлууд нээгдэхгүй байгаагаас шаардлагатай бараа материал, шатах тослох материалыг холбогдох газруудад зээл үүсгэн нийлүүлж байна.

Тав. ШҮҮХИЙН ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:

Орон нутгийн Сүлжээ-3, BBS телевиз, Багануурын амьдрал, Багануур нь юс сонинтой хамтран ажиллах гэрээ байгуулан цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр өгч мэдээлүүлж байна.

Шүүхийн шинэтгэлийн бодлогын талаар болоод шүүхүүд, Тамгын газраас зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар орон нутгийн Сүлжээ-3, BBS ТВ-үүдээр давхардсан тоогоор 48 удаагийн мэдээ мэдээлэл хүргэлээ. Багануур нь юс сонинд 25 удаа мэдээ нийтлүүлж, Эрүүгийн хэргийн анхан шатны 3-р шүүхийн Ерөнхий шүүгч Б.Оюунбат, Иргэний хэргийн анан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Цэцэгдулам, Тамгын газрын дарга Б.Эрдэнэбаяр нарын ярилцлага, “Шүүх ба олон нийт” илтгэлийн уралдаанд ирүүлсэн материалуудыг цувралаар нийтлүүлээ. Шүүхийн үйлчилгээг олон нийтэд ил тод нээлттэй хүргэх зорилгоор шүүхүүдийн шүүн таслах ажлын мэдээ, нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврын талаар дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, цагдаагийн хэлтэс, хороодод мэдээлэл хийж, холбогдох гарын авлага материалыг тараалаа.

Хамтран ажиллах гэрээ бүхий “Багануур нь юс” сонины, мэдээллийн сайтын дугаар бүрт зохион байгуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааны мэдээллийг байршуулахыг зорьж ажиллаж байна.

www.baganuurshuukh.mn сайтад дүүргийн анхан шатны 3-р шүүхийн үйл ажиллагааны мэдээ мэдээлэл Тамгын газрын даргын тушаалыг тогтмол байршуулж байна. Сайтад иргэний шүүх хуралдааны тов-364, тойм-333, шийдвэр 651, эрүүгийн шүүх хуралдааны тов 178, тойм 156, шийтгэх тогтоол 120-г байршуулсан байна. www.baganuurnews.mn, www.judcouncil.mn сайтад 24 мэдээ мэдээлэл байршуулсан байна.

Шүүхийн үйл ажиллагаатай хамааралтай асуудлаар олон нийтийн саналыг санал хүсэлтийн хайрцгаар болон baganuur_d@shuukh.mn хаягаар тогтмол хүлээн авч, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хангахад анхааран ажилласан. Шүүхээр үйлчлүүлсэн иргэд болон хэргийн оролцогчдоор санал асуулгын хуудас бөглүүлж саналын хайрцгаар хүлээн авч байна. Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс гаргасан шүүхийн багц хуулиудын шторкийг Д.Нацагдоржийн нэрэмжит талбайд байрлуулсан “Лед” дэлгэцээр тогтмол явуулж байгаагийн зэрэгцээ шүүхийн багц хуулиудын бичмэл сурталчилгааг 1500 ширхэгийг хэвлэн шүүхээр үйлчлүүлсэн иргэдэд тарааж байна.

Оны эхний хагас жилд хуралдсан эрүүгийн болон иргэний хуулиар хориглосноос бусад бүх шүүх хуралдааныг хурлын танхимын үүдний заланд байрлах дэлгэцээр нээлтэй дамжууллаа. Шилэн дансны тухай хууль, хэрэгжүүлэх журмын хүрээнд төсвийн зарцуулалтын холбогдох гүйлгээ, төсвийн мэдээг сайтад тухай бүрт байршуулж байна.

Нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт бичих талаар зөвлөгөө, нэхэмжлэлийн шаардлага, улсын тэмдэгтийн хураамжийн тухай, шүүхэд иргэний хэрэг хянан шийдвэрлэх хугацаа, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар нийт 2167 иргэнд холбогдох лавлагаа, мэдээлэл өглөө. Анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн бүрдүүлбэр, хэлбэр, агуулга, загвар гэх мэт мэдээлэл агуулсан 10 гаруй гарын авлага, Шүүхийн багц хуулиудын сурталчилгааны материалуудыг олшруулан эрүү, иргэний хэргийн шүүхийн байр, дүүргийн ЗДТГ-т тус тус байршуулаад байна.

2015 оны улирал тутмын “Шүүхийн мэдээ” сониныг гаргаж эхэлсэн ба одоогоор 3 дугаар 2400 ширхгээр олон нэгдүгээр улирлаас улирал нийтэд хүргэгдээд байна. Энэхүү сонин нь шүүхээс зохион байгуулж буй бүх үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгохын зэрэгцээ олон нийтийн хууль эрх зүйн талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилготой юм. Сониноо хороодын ажлын алба, өрхийн эмнэлгүүд, банкны салбаруудаар дамжуулан иргэдэд хүргэхийн зэрэгцээ ажилтнууд олон нийтийн газраар явж иргэдийн гарт нь хүргэж байна

Бусад ажлын талаар

- Төрийн албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгууллаа.
- Төрийн жинхэнэ албан хаагчид төрийн албаны тангараг өргөлөө.
- Багануур дүүргийн Шүүхийн 35 жилийн ойн баяр тэмдэглэлээ.
- Аудитын шалгалт хийгдлээ.
- Цагаан сар, Ахмадын баяраар өндөр настнууддаа хүндэтгэл үзүүллээ.
- ШЕЗ-ийн гишүүн **Ж.Эрдэнэчимэг тус шүүхэд ажиллалаа.**
- Байгууллагын ажилчдыг 1-дүгээр эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамрагдлаа.

- Олон улсын эмэгтэйчүүдийн баяраар эмэгтэйчүүдээ хүндэтгэл үзүүлэв. тэмдэглэв.
- Монгол цэргийн баяраар эрэгтэйчүүдийн дунд буудлага, цэргийн үүрэгтний нормативт үзүүлэлтээр тэмцээн зохион байгуулав.
- ДИХАШ-ны 2 дугаар шүүхийн шүүгч, ажилтнууд туршлага судаллаа.
- Хууль хяналтын байгууллагуудын уулзалт, ярилцлага зохион байгууллаа.
- Сургалтууд зохион байгууллаа.
- Хүүхдийн зөвлөлөөс “Аав ,ээж, би” тэмцээн зохион байгуулав.
- ШЕЗ-өөс зохион байгуулсан спортын наадам, ажил мэргэжлийн уралдааны Нийслэлийн бүсийн тэмцээнд 6 төрлөөр оролцож сагсан бөмбөг,ширээний теннисний эрэгтэй төрөлд 1-р байр эзлэв.
- ШЕЗ-өөс зохион байгуулсан спортын наадам, ажил мэргэжлийн уралдааны улсын аварга шалгаруулах тэмцээнд дээрх багаар оролцож төрөл тус бүрт шигшээ 8-р байрт шалгарсан амжилтаар тэмцээнийг өндөрлүүлэв.
- Хамт олноороо сайн үйлсийн аянд оролцож Т.Отгонзаяа охины БНСУ-д арьс солиулах эмчилгээнд, зүрхний төрөлхийн гажгийн улмаас БНЭУ-д хагалгаанд орохоор болсон Н.Ариунгоо охины эмчилгээний төлбөрт зориулан хандив өргөлөө.
- Зүүн аймгуудад гарсан гал түймрийн аюулд өртсөн иргэдэд тусламжийн гараа сунгалаа.
- ХБНГУ-ын Хансс Зайделын сангийн Урсулла Меннлле тэргүүтэй төлөөлөгчид тус шүүхтэй танилцлаа.
- Бүх нийтээр мод тарих үндэсний хөтөлбөрийн хүрээнд 200 мод тарилаа.
- Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчээр Г.Ариунаа томилогдож тангараг өргөлөө
- Дүүргийн БТСХ-ноос зохион байгуулсан “Эрүүл-Агаар-Эрч-Хүч” аялалд оролцож тэргүүн байр эзлэв.
- Хүүхдийн баярын үйл ажиллагаа зохион байгуулав.
- Шүүгч, ажилчид Дундговь аймгийн үзэсгэлэнт газруудаар аяллаа.
- Хэнтий аймгийн Хар зүрхний Хөх нуурт сургалтанд оролцохоор явж буй 40 гаруй шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд шүүхийн үйл ажиллагаатай танилцлаа.
- Хичээлийн шинэ жилээр Хүүхдийн зөвлөлөөс 1 дүгээр ангид элсэн суралцаж буй Базарсүрэнгийн Болдбаярт 50.000 төгрөгийн хадгаламжийн данс нээж өгч, амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой ажилчдын хүүхдүүдэд дэмжлэг үзүүллээ.
- Багануур дүүргийн Засаг даргаас санаачилсан “Сурагчдаа дэмжье” уриалгын хүрээнд Багануур дүүргийн шүүхийн Тамгын газар 1-р хорооны амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 10 хүүхдэд 100 ширхэг дэвтэр өгч суралцах үйлст нь дэмжлэг үзүүлсэн бол
- БНХАУ-ын Ардын дээд Шүүхийн Захиргаа хангамжийн газрын дарга Ван Шаонан тэргүүтэй зочид төлөөлөгчид шүүхийн үйл ажиллагаатай танилцав.
- Шүүгчийн туслах Б.Нарангэрэл намрын дунд сарын шинийн 15-ны билэгт сайн өдөр хуримаа хийсэн бөгөөд гэрлэх ёслолын ажиллагааг Шүүхийн тамгын газрын Залуучуудын зөвлөлөөс санаачлан ЗДТГ, Улсын бүртгэлийн хэлтэс, Өргөө соёлын ордонтой хамтран зохион байгууллаа.

- Шүүхийн захиргааны ажилтнуудын ажил мэргэжлийн уралдаан зохион байгууллаа.
- Онцгой байдал, МУЗН, Эрүүл мэндийн газраас сургалт зохион байгуулав.
- "Шүүх дэх иргэдийн төлөөлөгчдийн оролцоо" уулзалт ярилцлага зохион байгууллаа.
- Байгууллагын 2015-2016 оны хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагаа зохион байгууллаа.
- Багануур дүүргийн шүүхийг бүрэн камержууллаа.
- Ажил мэргэжлийн уралдаанд тэргүүн байр эзэлсэн багийг нийслэлд аялууллаа.
- Дүүргийн удирдлагуудад хууль сурталчиллаа.
- Төрийн албан хаагчдын баярыг угтаж зохион байгуулсан гар бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээнд оролцож эрэгтэй сагсан бөмбөгийн төрөлд хүрэл медаль хүртлээ.
- "Шүүхэд баярлалаа" сэдвээр 2 удаа ярилцлага авлаа.
- Шүүхийн мэдээ сонинг улирал тутам гаргаж, уншигчдад хүргэлээ.
- Багануур ньус сонин 25 мэдээ BBS, S3 телевизид 48 мэдээг өгч хамтран ажиллалаа
- Baganuurshuukh.mn сайтад 71 мэдээ мэдээлэл байршууллаа.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН БАГАНУУР ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА: Б.ЭРДЭНЭБАЯР